

Түр зуурын өөрчлөлтийг удирдах-Шугамын хавчаар!

2022 оны 7 сар



Зураг 1. Гоожилттой хавчлаганы дээр түр хавчаар байрлуулсан.

Үйлдвэрийн шугам хоолойд гоожилт үүссэн бөгөөд шугамыг хааж болохгүй учир засварыг зохих ёсоор гүйцэтгэх боломжгүй байсан. Тиймээс гоожилт тогтоох хавчаар ашиглах журмын дагуу шаардлагатай мэргэжилнүүдтэй зөвлөлдөж, 6 сарын хугацаагаар түр хавчаар ашиглахыг зөвшөөрсөн. Энэ хугацааны дараа хавчаарын нөхцөл байдлыг шалгах, үнэлгээ хийх, хэрэв шаардлага хангахуйц байвал зохих мэргэжилтнүүдээс дахин зөвшөөрөл авах ёстой байсан. Хоёр жил өнгөрсний дараа тус хавчаар гоожиж эхэлсэн. Дахин үнэлгээ хийх болон зөвшөөрөл олгох процесс огт явагдаагүй байсан бөгөөд уг хавчаарыг компанийн дүрэм, журамд зөвшөөрснөөс хэт урт хугацаанд ашигласан байсан.

Шугамын хавчаар бол засвар үйлчилгээг зохих ёсоор хийх боломжгүй үед ашигладаг түр зуурын шийдэл бөгөөд жинхэнэ шугам хоолойноос чанарын хувьд сул юм. Түүнчлэн шугам хоолойд анх гоожилт үүсгэсэн шалтгаан арилаагүй хэвээр байгаа үед бүрэн засвар үйлчилгээ зайлшгүй шаардлагатай. Өөрөөр хэлбэл, шугамын хавчаар нь “тогтвортой” шийдэл биш юм.

Бүх түр зуурын засварыг компанийн Өөрчлөлтийн Менежментийн процессын дагуу зохицуулах хэрэгтэй. Хамгийн шилдэг арга бол “ээлжит” хэлбэрийн засварын ажлын захиалга үүсгэх буюу дараагийн ээлжит засварын хугацаа болох үед гоожилттой шугам хоолойд засвар үйлчилгээ хийх эсвэл шинээр солих ажлын төлөвлөгөө боловсруулах юм.

Та мэдэх үү?

- Шугамын хавчаар нь гоожилт тогтоох зорилгоор хавчаар ашигладаг инженерийн шийдлүүдийн нэг юм. Хавчаар гоожилттой хэсгийн эргэн тойронд даралтан бүрхүүл үүсгэж, улмаар даралтаар шахагдсан полимерүүд доторх зайг дүүргэх буюу нүх сүвийг бөглөдөг. Тиймээс энэ нь гоожилтыг үр дүнтэй зогсооход ашиглагддаг түр зуурын арга юм.
- Аюул эрсдэлтэй үйл ажиллагаанд ямар нэгэн өөрчлөлт хийгдэх бол тухайн сайтын Өөрчлөлтийн Менежментийн (МОС) процессын дагуу үзлэг шалгалт, зөвшөөрөл болон хяналтын арга хэмжээг хэрэгжүүлэх хэрэгтэй.
- Шугамын хавчаар удаан хугацаагаар ашиглахад зориулагдаагүй. Шугам хоолой, хавчлагыг шугамын үндсэн шаардлагад тохирсон эд ангиар солих ёстой.
- Шугамын хавчаартай адил түр засварууд хэдийгээр нүдэнд ил харагдаж байдаг ч хараа хяналтаас гарах нь амархан байдаг.
- Хөрөнгийн бүрэн бүтэн байдлыг хангах системүүдийн зорилго бол үйлдвэрлэлийн тоног төхөөрөмжийн найдвартай байдлыг хадгалах юм. Эдгээр системүүд доголдвол тоног төхөөрөмжийн найдвартай байдал алдагдаж, аюулгүй ажиллагаа эрсдэлд орно.
- Тойруу шугамд холбосон удирдлагын систем эсвэл төхөөрөмж нүдэнд анзаарагдахгүй байх боломжтой.

Та юу хийж болох вэ?

- Түр засвар хийгдсэн эд ангитай тааралдвал ахлах ажилтнаасаа энэ талаар лавлаж асуу. Таны асуулт үзлэг шалгалтын хугацаа нь хэтэрсэн засварт анхаарал хандуулах нөхцлийг бүрдүүлж болзошгүй.
- Түр хугацааны засвар бүрд батлагдсан МОС буюу өөрчлөлттэй холбоотой түр зөвшөөрөл олгогдсон байх ёстой. Түр зөвшөөрөгдсөн МОС тус бүрийг нарийн хянах хэрэгтэй бөгөөд үүнд дараагийн ээлжит засварын үеэр шинээр солих буюу тогтвортой шийдлийг хэрэгжүүлэх хүртэлх тогтмол үзлэг шалгалт, давтан зөвшөөрөл зэрэг арга хэмжээнүүд багтана.
- Үйлдвэрлэлийн процессын олон хэсгийг үзлэг шалгалт эсвэл тохиргоо хийх зорилгоор түр тойруу шугамд холбодог. Хэрэв ийм тохиолдолтой тааралдвал ахлах ажилтнаасаа лавлаж асуу. Зөвшөөрөлгүйгээр юуг ч өөрчилж болохгүй.
- Тойруу шугамд холбосон удирдлагын системийг олж тогтоох амаргүй байдаг. Зарим тойруу шугамд холбосон удирдлагын системийг идэвхгүйжүүлсэн эсвэл ашиглалтаас гаргасан байж болно.

Түр гэдэг бол түр хугацаа л гэсэн үг.